



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар АЖ66

Хэрлэн сум

Цэрэг татлага зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны н/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 2022 оны 9 дүгээр сарын 30-аас 2022 оны 10 дугаар сарын 25-ны хооронд явуулсугай.

2.Цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
Гишүүд:	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа
	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга, Дэд хурандаа
	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
	Д.Оюунгэрэл	Нэгдсэн эмнэлгийн дарга
	Г.Дашдаваа	Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төвийн захирал
	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
Нарийн бичгийн дарга:	А.Баярбат	Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч

3.Цэрэг татлагын хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Цэрэг татлагын эмч нарын үзлэгийг "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг

тодорхойлох журам"-ын дагуу шинжилгээ, оношлогоог үндэслэн чанартай зохион байгуулахыг Нэгдсэн эмнэлэг (Д.Оюунгэрэл)-т, цэргийн албанд тэнцсэн хугацаат цэргийн албанд татагдагчдаас коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах, эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т, цэргийн албанд татагдагчдын боловсролын түвшинг тогтоох, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг албан бус сургалтанд хамруулахыг Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төв (Г.Дашдаваа)-д, цэргийн албанд татагдагчдын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү)-т, цэрэг татлагын байрны дотоод дэг журам сахиулах, цэрэг татлагын товчооны ажилд дэмжлэг үзүүлэхийг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат)-т, цэргийн албанд татагдагчдын болон тэдний ар гэрийн талаар нарийвчлан судлахыг Тагнуулын хэлтэс (дэд хурандаа О.Баярлхагва)-т тус тус үүрэг болгосугай.

5.Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх, сумын Эрүүл мэндийн төвд коронавируст халдвар (Covid-19)-ын түргэвчилсэн шинжилгээ, цусны бүлэг тогтоох, хэвлийн чанд авиан оношлогоо, шээсний шинжилгээг урьдчилан хийсэн байх, Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, Цэргийн албанд татагдагчдыг үдэж мордуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авах, тэднийг ажлын байранд зуучлах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бүрэлдэхүүнийг үүрэг даалгавраар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн албанд татагдагчдыг аймгийн цэрэг татлагын байранд ирүүлэх, цэргийн албанаас халагдагсадыг бичиг баримттай нь хүлээн авч, цэргийн тоо бүртгэлд тусган, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгч, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб (хурандаа Н.Хүрэлээ)-т даалгасугай.

7.Цэрэг татлагын үед болон тээвэрлэлтийн явцад коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтгэлийг тогтоосон хугацаанд хийх, улсын Онцгой комиссоос гаргасан журмыг сайтар мөрдөж



3.

ажиллах, Цэрэг татлагын товчооны гишүүд, эмч нар болон цэргийн албанд татагдагчдыг нэг удаагийн амны хаалт, ариутгалын бодисоор хангах, цэрэг татлагатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хянан шийдвэрлэх, Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан хуульд заасан шаардлага хангасан залуучуудыг хугацаат цэргийн албанд татаж, 2022 оны 10 дугаар сарын 20-д багтаан алба хаах цэргийн ангиудад хүлээлгэн өгч, дүнг 2022 оны 10 дугаар сарын 25-д танилцуулахыг Цэрэг татлагын товчоо (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны  
09 дугаар сарын 15-ны  
дугаар захирамжийн хавсралт

2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын  
зохион байгуулах хуваарь

№	Сум, багийн нэр	Үзлэгээр орох хүний тоо	Хяналтын тоо	Цэрэг татлагад орох газар	Үзлэгт бэлэн байх	
					Сар едер	Цаг
1.	Өлзийт	40		Өлзийт	09.30	09.00
2.	Өмнөдэлгэр	242		Өмнөдэлгэр	09.30	13.00
3.	Гурванбаян	36		Гурванбаян	10.01	14.00
4.	Батширээт	109		Батширээт	10.02	09.00
5.	Биндэр	155		Биндэр	10.02	14.00
6.	Баян-Адарга	138		Баян-Адарга	10.03	09.00
7.	Дадал	129		Дадал	10.04	09.00
8.	Норовлин	109		Норовлин	10.04	14.00
9.	Баян-Овоо	88		Баян-Овоо	10.05	10.00
10.	Батноров	138		Батноров	10.05	13.00
11.	Бэрх	123		Бэрх	10.06	10.00
12.	Хэрлэн	594		Хэрлэн	10.13	09.00
13.	Баянхутаг	13		Хэрлэн	10.14	09.00
14.	Галшар	18				
15.	Бор-Өндөр	48				
16.	Дархан	10				
17.	Баянмөнх	8				
18.	Дэлгэрхаан	15				13.00
19.	Хэрлэнбаян- Улаан	2				
20.	Цэнхэрмандал	17				
21.	Жаргалтхаан	20				
22.	Мөрөн	19				
	Нийт дүн					